



MONGOLIAN NATIONAL ASSOCIATION
FOR WHEELCHAIR USERS


МОНГОЛЫН ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭДИЙН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

Хөгжлийн бэрхшээл ба жендер



Хүний эрх гэж юу вэ?

- Хүний эрх гэдэг нь хүн болж төрснийхөө төлөө, хүн шиг амьдрахад зайлшгүй шаардлагатай наад захын стандарт
- Хүний эрх нь нь арьс өнгө, үндэс угсаа, хэл соёл, шашин шүтлэг, нийгмийн байдал, бэрхшээлийн онцлог зэргээс үл хамааран хүн бүрт төрөхөөс заясан эрх, эрх чөлөө
- Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага



Хүний эрхийн зарчим



- Тэгш байх зарчим
- Хуваагдашгүй байх зарчим
- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим
- Түгээмэл салшгүй байх зарчим
- Хүн нэр төртэй үнэ цэнэтэй байх зарчим
- Харилцан хамааралтай байх зарчим



Хүйс ба жендэр

ХҮЙС

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн хромосом, үржихүйн эрхтэн, гомоог шүүрлээр нөхцөлгдсөн биологийн шинж чанар, ялгааг илэрхийлнэ. Жишээ нь: эмэгтэйчүүд хүүхэд төрүүлж, хөхүүлдэг; эрэгтэйчүүд жирэмслэх боломжгүй, дууны өнгө нь өөрчлөгддөг зэрэг.

Төрөлх/байгалиас заяагдмал.

Өөрчлөгдөхгүй, байнгын тогтсон шинжүүд.

Ижил хүйсийн хүмүүсийн хувьд ижил.

ЖЕНДЭР

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдэд нийгмээс оноосон, хуваарилсан, улмаар шахалт үзүүлж буй хүлээлт, эрх мэдэл, үүрэг харууцлагыг илэрхийлдэг. Жишээ нь: эрэгтэй хүн орон гэрээ бэлдэх ёстой. Эр хүн үйлж болохгүй. Эмэгтэй хүн гэр бүлийн гишүүдээ асран халамжлах ёстой зэрэг.

Олдмол/нийгмээс суралцдаг, оноогог, хуваарилдаг, шахалт үзүүлдэг, тулгадаг

Өөрчлөгддөг, хувьсдаг, олон талт ухагдахуун. Өөр өөр соёл иргэншлийн хувьд ялгаатай.

Ижил хүйсийн хүмүүсийн гунг ч ялгаа байдаг.



Хүйс ба жендэр

01

Эмэгтэйчүүд хүйсээсээ
хамааран ялгаварлан
гадуурхалтад илүү өртөг.

02

Эмэгтэйчүүдийн эрх
нийтийн хүрээнд төдийгүй
гэр бүл, харилцааны
хүрээнд, хувийн орон зайд
зөрчигддөг.

03

Эмэгтэйчүүдийн
амьдралын туршлага
эрэгтэйчүүдийнхээс
ялгаатай.



04

Анги давхарга, хөгжлийн, бэрхшээл,
нас, бэлгийн баримцаа, угсаа гарал,
шашин зэрэгт суурилсан бусад
төрлийн ялгаварлан гадуурхалтад
эмэгтэйчүүдэд илүү хүндээр эсвэл
өөр хэлбэрээр тусдаг.

05

Энэ нь гэр бүл, хамт олон,
нийгмийн хүрээнд эрэгтэйчүүдийг
дээрд үзэж, тэдэнд илүү эрх
мэдэл, боломж, нөөц ыололцоог
хувиарлах, хэм хэмжээг тулган
хэрэгжүүлдэг, эцгийн эрхт ёсны
тогтолцоотой холбоотой.

ЯЛГАВАРЛАЛ

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд
хүйс/жендэрийн шинжээр
ИЛТ ялгаатай хангах
эмэгтэйчүүдийн эрхийг
сулруулах эсхүл үзүйсгэх
нөлөө бүхий аливаа үйлдэл,
эс үйлдэл

ГАДУУРХАЛ

Эмэгтэйчүүдийн хүний эрх,
эрх чөлөөг нийгмийн хэм
хэмжээ, жендэрийн хэвшмэл
ойлголт зэрэг шалтгааны
улмаас үзүйсгэх,
эмэгтэйчүүдийн эрх, эрх
чөлөөгөө эгдлэх, хэрэглэх
боломжийг нь хаах.

ХЯЗГААРЛАЛ

Эмэгтэйчүүдийн хүний эрх,
эрх чөлөөгөө эгдлэх,
хэрэглэх, хүлээн
зөвшөөрүүлэх явдлыг
эрэгтэйчүүдийнхтэй
харьцуулахад илүүтэй
хязгаарлах

Шууд бас шууд бус ялгаварлан гадуурхалт

Шууд ялгаварлан гадуурхалт

- ХБ-тэй хүнийг
ажилд авахаас
татгалзах
- Янз бүрээр нэрлэх,
хочлох
- Үйлчилгээ
үзүүлэхээс
татгалзах



Шууд бус ялгаварлан гадуурхал

- ЕБС-н сурах бичиг
харааны
бэрхшээлтэй сурагчи
д хүртээмжгүй байх
- Нийтийн
тээвэр тэргэнцэртэй
иргэдэд хүртээмжгүй
байх

Хөгжлийн бэрхшээл ба ялгаварлан гадуурхалт

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ихэвчлэн дараах шалтгааны улмаас байнга ялгаварлан гадуурхалтад өртдөг.
 - Бид эмэгтэй.
 - Бид хөгжлийн бэрхшээлтэй.
 - Бидний ихэнх нь ядуу амьдралтай.
- Гэр бүл болох, ажлын байранд “зөв төрхтэй бус” хэмээн адлагддаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд ихэвчлэн боловсрол эзэмших боломжгүй байдаг.
- Мэргэжил олгох ямар ч сургалтад хүртээмж болоэн хүмүүсийн хандлагаас хамааран хамрагдах боломж байдаггүй.
- Мөн дээрээс нь бие махбодын, сэтгэл санааны болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг.
- Хөгжлийн бэрхшээлтэй бүх эмэгтэйчүүд гэртээ эсвэл хүмүүсийн дунд байхдаа шийдвэр гаргах эрх маш ховорхон тохиодог.



- 2 эмэгтэй тутмын 1 нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой
- 61.3% нь хөдөлмөр эрхэлдэггүй
- Судалгаанд хамрагдсан ХБ-тэй охид, эмэгтэйчүүдийн 50 хувь нь 300 000 мянгаас доош орлоготой байна. Энэ нь өрхийн гэр бүлийн орлогын 11 хувийг бүрдүүлж байна.
- Бэлгийн болон НҮЭМ-н мэдээллийг 84 хувь нь албан бус, эх сурвалжаас авдаг.
- Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэсэн эмэгтэйчүүдийн 22 хувь нь бусдын дарамт шахалт, нөлөөллөөр тус аргуудыг хэргэлсэн.


Үүнд 46 хувь нь аав ээж, нөхөр найз залуу, 35 хувь нь эмч, эмнэлгийн ажилтанууд хамгийн их дарамт, шахалт, нөлөөллийг үзүүлсэн.

Оролцогчдын 3 хүн тутмын 1 нь БЗДХ/ХДХВ хэрхэн халдварладаг талаар мэдлэггүй, 17 хувь ямар нэг халдвар авч байсан.

Төрөх эмнэлэгт үйлчлүүлсэн эмэгтэйчүүдийн 63 хувь нь бэрхшээл асуудалтай тулгарсан. (хандлага, тохирсон зөвлөгөө, харилцаа, орчны хүртээмж)

- Дунджаар 5 эмэгтэй тутмын 1 нь бэлгийн дарамт хүчирхийллийн хохирогч байсан төдийгүй хүчирхийлэгч нар нь 19,9 гэр бүлийн гишүүд, ойр дотныхон нь байсан.
- Хүчирхийлүүлсэн тухайгаа ХБ-тэй эмэгтэйчүүдийн 71 хувь нь хэн нэгэнд хэлж байгаагүй.

Хөгжлийн бэрхшээл ба Эрх мэдлийн тэнцвэргүй байдал



Үйлчилгээ авсан байдал

Хүчирхийлэлтэй харилцаа байсан бол ямар нэг байгууллагад хандаж байсныг тодруулахад 70.2% нь хандаж байгаагүй, 29.8% хандаж байсан.

Гэр бүлийн хүчирхийллийн тусламжийн утас болон хамгаалах байранд хандах тухай ойлголт 90 орчим хувьд байхгүй




Байгууллагад хандаж тусламж хүссэн эмэгтэйчүүдийн 51.3% нь шийдвэрлүүлж чадаагүй

Өөртөө итгэлгүй байдал ба төрийн үйлчилгээнд итгэл итгэл бага, төрийн үйлчилгээний хүртээмжгүй байдал

Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд цагдаад хандах итгэл 24% буюу хамгийн өндөр байна.

Бэлгийн хүчирхийлэл



Туслах хэрэгсэл болох таяг,
сонсголын аппаратыг эвдэх

Харааны бэрхшээлтэй хүний эд
юмс, тавилганы байрлалыг
хэлэхгүйгээр өөрчлөх

Эмнэлэгт үзлэг хийлгэхээр
очиход нь бусад хүмүүсийн өмнө
хувцасаа тайлахыг албадах

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн
хүүхдийг шоглох

Бэлгийн хүчирхийлэл

Хүчирхийлэгч
хөгжлийн бэрхшээлтэй
хүний ойр дотны хүн
байх нь олон

Олон нийтийн дунд ордоггүй,
найз нөхөдгүй, эсрэг хүйсийн
хүнийхээ бэлгийн харилцааны
талаар мэдлэггүй тул өөр
сонголт байхгүй хэмээн
ойлгож, хүчирхийллийг
хүлээн зөвшөөрөх хандлага
өндөр.



Хүчирхийлэлд өртсөнөө хэн
нэгэнд хэлэх үед, гэр бүлийн
гишүүд болон бусад хүмүүс
ихэвчлэн хүчирхийлэгчийг
өмөөрч өөрийг нь
буруутгадаг

Сонголт, хэл ярианы
бэрхшээлтэй хүн
хүчирхийлэлд өртсөн бол
бусдаас тусламж авахдаа
илүү их хүнд замыг туулдаг

Тусалсаны хариуд,
асарсаны хариуд бэлгийн
харилцаанд орохыг тулгах

Сэтгэл санааны хүчирхийлэл

Ганцааранг нь үлдээж,
бусдаас тусгаарлан, хэнд ч
хэрэггүй мэтээр хандах

Аливаа зүйлийг хийх арга
хэлбэр нь бусдаас өөр
байгаад дургүйцэж, янз янзын
нэрээр дуудаж цоллох

Хөгжлийн бэрхшээлтэй гэр
бүлийн гишүүнтэй гэдгээсээ
ичдэг, түүнийгээ байнга хэлж,
илэрхийлэх



Сонголын бэрхшээлтэй
хүний сонсохгүйг нь
далимдуулж элдэв муу
үгээр бусдад ярих.

Хүсэл бодлын үл
хайхран, өмнөөс нь
шийдвэр гаргах




Үл хайхрах хүчирхийлэл

- Олон цагаар оронд хэвтүүлэх
- Хувцасаа өмсөх, гар нүүрээ угаахад нь туслахгүй байх
- Бохирдсон цагаан хэрэглэл, норсон хувцасыг нь солихгүй байх
- Боловсрол эзэмших, нийгмийн дунд орохыг нь эсэргүүцэж, татгалзах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрахаас татгалзах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ганцааранг нь тусгаарлах нь
- Хоол өгөхгүй байх
- Хэрэгтэй эмгийг нь авч өгөхөөс татгалзах

Эдийн засгийн хүчирхийлэл

- Мөнгө орлогоо захиран зарцуулах эрх мэдэл олгохгүй байх.
- Эдийн засгийн эх үүсвэрээс нь салгаж, орлого олох боломжгүй болгох.
- Нэр дээр нь зээл авах, өрөнд оруулах.
- Хэрэглээг нь хязгаарлах.
- Эд хөрөнгө эзэмших, өмчлөх, ашиглах боломжийг нь хаагдуулах.
- Халамж, тэтгэвэрийн мөнгийг нь өөрт нь зарцуулахгүй байх.
- Эд юмаа эвдэх



Эдэлвэл зохих эрх - Төрийн хүлээх үүрэг



ХҮНДЭТГЭХ

Хүний эрх эдлүүлэхээс хөнглөнгөөс оролцох, саад хийхээс сэргийлэх

ХАМГААЛАХ

Хүний эрхийн зөрчлөөс хүн бүрийг хамгаалах

ХАНГАХ

Үнсэн эрх эдлэх ахиц гэвшилтэт, эерэг алхамыг авах



ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

48076-002: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ
САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ (L3605/G9191:MON48076)



ENSURING INCLUSIVENESS
SERVICE DELIVERY

PWD



**MONGOLIAN NATIONAL ASSOCIATION
FOR WHEELCHAIR USERS**